

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн тайлан.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



БУЯНТ-УХАА ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА С.ЦЭЦГЭЭ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/230
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1. ОРШИЛ

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Буянт-Ухаа дахь гаалийн газрын дарга С. Цэцгээ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Номгон Аудит ХХК-ийн аудитор О. Мандах хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа дахь гаалийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Номгон Аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Буянт-Ухаа дахь гаалийн газар нь "Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын үндсэн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Гаалийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

2018 онд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2018 онд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдах өөрийн эзэмшлийн барилга, байгууламж, газар байхгүй тул дахин үнэлгээ хийгдээгүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд Гаалийн ерөнхий газрын хэмжээнд Гаалийн ерөнхий газрын даргын 2014 оны 01дүгээр сарын 23-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бичиг баримтыг мөрдөн ажиллаж байна. 2018 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтанд өөрчлөлт ороогүй байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Буянт-Ухаа дахь гаалийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Буянт-Ухаа дахь гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь өөрөө орлого олж үйл ажиллагаа явуулдаггүй төсвөөс санхүүждэг тул үр дүнгийн тайлангийн зардлаар тооцох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 2,970,953.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 59,419.07 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 51 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/ Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	1,623.50	
	Дүн	2	1,623.50	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас орсон орлогыг буцаан төвлөрүүлсэн 396.9 мянган төгрөгийн гүйлгээг авлагаар тусгаагүйг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.
- Үйл ажиллагааны зардлын тайланд нийгмийн даатгалаас буцаан олгосон шимтгэлийн орлого 851.0 мянган төгрөгийг орлогод аваагүй. Мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд үндсэн хөрөнгийн шинжтэй 12,056.8 мянган төгрөгийн хөрөнгийг зардлаар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс, тэтгэврийн даатгал, үндсэн цалин, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлуудад 2,263.9 мянган төгрөгийн зардал дутуу, 866.5 мянган төгрөгийн зардлыг илүү тусгаснаас тайлант үеийн үр дүн 11,510.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын сангийн тэтгэмжийн орлого, зарлагыг 14,372.9 мянган төгрөгөөр эдийн засгийн ангиллыг буруу сонгосон. Нийт 25,883.3 мянган төгрөгийн гүйлгээг алдаатай тайлагнасныг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дансын бичилт буруу хийгдсэнээс өглөгийн дансны үлдэгдэл 149.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.
- Тендерээр бэлтгэсэн хөрөнгөнөөс 12,056.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогодоогүй байсаныг санхүүгийн тайлангийн явцад залруулсан.

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан 2018 онд 2,890,254.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,773,193.9 мянган төгрөг буюу 95.9 хувьтай. 2018 оны төсвийн зардал 117,060.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Энэ нь Хөшигийн хөндийн Олон улсын нисэх буудал 10 дугаар сард ашиглалтанд орохтой холбоотой орон тоо, цалингийн төсвийг нэмж тодотгон батласан боловч ашиглалтанд орж үйл ажиллагаа явуулж эхлээгүйгээс төсвийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Буянт-Ухаа дахь гаалийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Буянт-Ухаа дахь гаалийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2018 оны жилийн дүнгээр шатахууны орлого зарлагын гүйлгээний дүн няравын шатахууны тайлан, журналын бичилттэй тохирсон боловч 2, 3 дугаар саруудын няравын тайлангийн орлого, зарлагыг 1,623.5 мянган төгрөгөөр журналын бичилттэй зөрүүтэй тайлагнасан.

3.1.2 Эрсдэл:

Бараа материал шамшигдуулах, бараа материал дутагдах, авлага өглөгийн тооцоо үүсэх, тайлан балансд бараа материалын орлого, зарлага дутуу тусгагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг байнгын системийн аргаар бүртгэж, орлогоор хүлээн зөвшөөрсний дараа зарлагдаж, няравын тайланг сар бүр хянаж баталгаажуулж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Няравын тайланг сар бүр хянан баталгаажуулж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2018 оны жилийн эцэст тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлийн дүн журналын үндсэн хөрөнгийн дүнтэй зөрүүтэй. Үндсэн хөрөнгө хүлээн авах, дансаас хасах анхан шатны маягт хөтлөөгүй.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгө шамшигдуулах, завших, тайлан балансыг буруу тайлагнах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн хорооны бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам” батлах тухай 86 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг журмын дагуу явуулах Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.7, 72 дугаар зүйлийн 72.4.1, 72.4.4, 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаж тооллого тооцоог чанартай хийх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тооллогыг цаг хугацаанд нь чанартай хийж өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 5 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,330,931.00	76,354,823.00
33	АВЛАГА	156,000.00	385,059.00
33500	Бусад авлага	156,000.00	385,059.00
3351	Байгууллагаас авах авлага	156,000.00	385,059.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,174,931.00	75,969,764.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	21,667,081.00	65,486,175.00
35400	Хангамжийн материал	1,507,850.00	10,483,589.00
35410	Бичиг хэргийн материал	860,260.00	936,000.00
35420	Аж ахуйн материал	235,900.00	3,824,260.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	2,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	411,690.00	3,723,329.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	489,909,977.57	1,895,094,173.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	489,909,977.57	1,894,953,548.54
39200	Биет хөрөнгө	489,656,852.37	1,894,953,548.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,136,328.00	9,136,328.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	4,872,708.48	5,481,797.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	195,331,480.00	276,331,480.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	153,664,813.38	183,831,480.06
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	941,892,628.68	2,594,444,867.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	586,122,175.39	946,066,514.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,818,515.97	236,071,805.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	76,862,403.03	85,651,139.99
39300	Биет бус хөрөнгө	253,125.20	140,625.00
39301	Програм хангамж	3,200,000.00	3,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	2,946,874.80	3,059,375.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	513,240,908.57	1,971,448,996.54
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	156,000.00	531,846.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	156,000.00	531,846.30
41300	Өглөг	156,000.00	531,846.30
41360	Бусад өглөг	156,000.00	
41361	Байгууллагад өгөх өглөг	156,000.00	
41362	хувь хүмүүст төлөх өглөг		364,454.00
41364	НДШ-ийн өглөг		167,392.30
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	513,084,908.57	1,970,917,150.24
51	Засгийн газрын хувь оролцоо	964,525,286.31	964,525,286.31
51101	Засгийн газрын оруулсан капитал	964,525,286.31	964,525,286.31
51200	Хуримтлагдсан үр дүн	-455,099,085.24	1,002,733,156.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-455,099,085.24	-455,099,085.24
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,457,832,241.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,658,707.50	3,658,707.50
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	513,240,908.57	1,971,448,996.54

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,705,838,388.57	4,428,785,665.86
11	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО		850,999.49
1110	Нийгмийн даатгалын сангаас олгосон орлого		850,999.49
110101	Шууд бус орлого		850,999.49
111102	Нийгмийн даатгалын буцаан олголт		850,999.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,768,620.00	1,537,680,666.37
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материалао	15,768,620.00	12,175,728.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /хөрөнгө/		1,525,504,938.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,690,069,768.57	2,890,254,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,588,615,100.00	2,890,254,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,588,615,100.00	2,890,254,000.00
1311	Нэмэлт санхүүжилт	3,300,000.0	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,765,909,285.94	2,970,953,424.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,389,198,123.00	2,432,151,040.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,718,388,207.03	2,853,873,677.44
21	ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ, НДШ	2,389,198,123.00	2,432,154,040.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,145,492,425.98	2,168,408,443.61
210101	Үндсэн цалин	2,012,102,656.43	1,909,983,857.31
210102	Нэмэгдэл	63,984,769.55	187,721,386.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,405,000.00	70,703,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	243,705,697.02	263,745,597.27
210201	Тэтгэврийн даатгал	156,788,596.27	177,527,193.69
210202	Тэтгэмжийн даатгал	10,864,639.65	10,777,302.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,729,272.72	21,554,599.83
210204	Ажилгүйдлийн даатгал	10,864,639.65	10,777,302.04
210205	Эрүүл мэндийн даатгал	43,458,548.73	43,109,199.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,200,000.00	64,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,350,000.00
210304	Байрны түрээс	60,000,000.00	59,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,290,576.87	37,986,494.49
210401	Бичиг хэрэг	8,247,060.00	7,929,059.00
210402	Тээвэр, шатахуун	22,026,360.00	25,377,361.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,274,296.87	1,203,875.49
210404	Ном, хэвлэл		1,256,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	483,810.00	452,475.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	259,050.00	1,767,724.00
2105	Нормативт зардал	805,695.00	
210502	Хоол, хүнс	805,695.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,354,700.00	24,367,800.00

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл		799,300.00
210604	Урсгал засвар	18,354,700.00	23,568,500.00
2107	Томилолт, зочны зардал		290,000.00
210702	Дотоод албан томилолт		290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,372,429.22	96,889,627.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,034,822.22	45,267,126.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,566,345.00	5,267,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		31090000
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,771,262.00	10,604,661.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,166,682.94	197,985,714.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,660,230.00	3,033,372.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,604,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	162,506,452.94	193,347,542.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,521,078.91	117,079,746.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,099,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,099,900.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,421,178.91	117,079,746.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,421,178.91	117,079,746.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-60,070,897.37	1,457,832,241.67
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	431,818.25	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	431,818.25	
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-60,502,715.62	1,457,832,241.67

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,640,841,807.00	2,890,636,428.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,640,685,807.00	2,890,636,428.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,588,615,100.00	2,890,254,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,588,615,100.00	2,890,254,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,300,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300,000.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	48,770,707.00	362,828.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	48,770,707.00	362,828.00
300001	Нэр данс зөрүүтэй орлого	156,000.00	19,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,640,841,807.00	2,890,636,428.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,389,198,123.00	2,431,405,147.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,544,394,021.09	2,773,193,853.25
21	ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ, НДШ	2,389,198,123.00	2,431,405,147.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	2,147,728,735.77	2,158,376,747.41
210101	Үндсэн цалин	1,318,611,700.00	1,102,773,628.67
210102	Нэмэгдэл	580,149,861.99	733,642,967.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,467,173.78	66,598,400.00
210104	Урамшуулал	177,500,000.00	255,361,751.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,469,387.23	273,028,399.68
210201	Тэтгэврийн даатгал	166,920,787.23	190,856,579.33
210202	Тэтгэмжийн даатгал	18,637,200.00	23,844,720.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,909,700.00	15,553,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,727,400.00	3,888,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,274,300.00	38,884,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,200,000.00	64,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	4,350,000.00
210304	Байрны түрээс	60,000,000.00	59,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,518,446.87	38,715,075.49
210401	Бичиг хэрэг	2,547,800.00	4,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,189,000.00	28,689,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,274,296.87	1,453,875.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	487,550.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,019,800.00	4,122,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,577,784.00	118,648,898.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,013,084.00	67,787,298.00
210602	Тавилга		15,699,600.00

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	790,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	19,774,700.00	33,662,000.00
2107	Томилолт, зочны зардал		290,000.00
210702	Дотоод албан томилолт		290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,601,167.22	115,134,732.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,034,822.22	54,995,232.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,236,945.00	4,858,140.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,400.00	409,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		43,214,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,000,000.00	6,996,860.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,298,500.00	4,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,298,500.00	4,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,447,785.91	117,442,574.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,870,607.00	
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	48,770,707.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,099,900.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,577,178.91	117442574.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,577,178.91	117442574.75
213304	Хөрөнгийн		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IX	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		
X	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн				
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	-455,099,085.24	513,084,908.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн			1,457,733,025.00	1,457,733,025.00
2018 оын 12 сарын 31-р үлдэгдэл	964,525,286.31	3,658,707.50	1,002,633,939.76	1,970,817,933.57

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,890,254,000.00	2,773,193,853.25	117,060,146.75	95.95
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,890,254,000.00	2,773,193,853.25	117,060,146.75	95.95
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,890,254,000.00	2,773,193,853.25	117,060,146.75	95.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341,988,800.00	341,788,706.16	193,426.51	99.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	2,275,236,800.00	2,158,376,747.41	116,860,052.59	94.86
210101	Үндсэн цалин	1,138,484,000.00	1,102,773,628.67	35,710,371.33	96.86
210102	Нэмэгдэл цалин	790,100,000.00	733,642,967.74	56,457,032.26	92.85
210103	Унаа хоолны нэмэгдэл	72,652,800.00	66,598,400.00	6,054,400.00	91.67
210104	Урамшуулал	274,000,000.00	255,361,751.00	18,638,249.00	93.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	273,028,400.00	273,028,399.68	0.32	100.0
210201	Тэтгэврийн даатгал	195,258,900.00	190,856,579.33	4,402,320.67	97.75
210202	Тэтгэмжийн даатгал	19,442,400.00	23,844,720.35	-4,402,320.35	122.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,553,900.00	15,553,900.00		100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,888,500.00	3,888,500.00		100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	38,884,700.00	38,884,700.00		100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,200,000.00	64,200,000.00		100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,350,000.00	4,350,000.00		100.0
210304	Байрны түрээс	59,850,000.00	59,850,000.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,754,600.00	38,715,075.49	39,524.51	99.90
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	4,000,000.00		100.0
210402	Тээвэр, шатахуун	28,689,000.00	28,689,000.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,469,100.00	1,453,875.49	15,224.51	98.96
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,600.00	450,000.00	600.00	99.87
210406	БҮТЭЗүйлс	4,145,900.00	4,122,200.00	23,700.00	99.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,690,000.00	118,648,898.00	41,102.00	99.97
210601	Багаж, техник хэрэгсэл	67,790,400.00	67,787,298.00	3,102.00	100.0
210602	Тавилга	15,699,600.00	15,699,600.00		100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00		100.0
210604	Урсгал засвар	33,700,000.00	33,662,000.00	38,000.00	99.89
2107	Томилолт, зочны зардал	290,000.00	290,000.00		100.0
210702	Дотоод албан томилолт	290,000.00	290,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,254,200.00	115,134,732.67	112,800.00	99.90

Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,001,900.00	54,995,232.67	6,667.33	100.0
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,600,000.00	4,600,000.00		100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,859,100.00	4,858,140.00	960.00	99.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	409,700.00	409,700.00		100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	168,700.00	60,000.00	108,700.00	35.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,214,800.00	43,214,800.00		100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,000,000.00	6,996,860.00	3,140.00	99.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	4,800,000.00		100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,800,000.00	4,800,000.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,890,254,000.00	2,773,193,853.25	117,060,146.75	95.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,890,254,000.00	2,773,193,853.25	117,060,146.75	95.95
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,890,254,000.00	2,773,193,853.25	117,060,146.75	95.95

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Буянт-Ухаа дахь гаалийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.15			САГ-2019/355/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Буянт-Ухаа дахь гаалийн газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2018 оны жилийн дүнгээр шатахууны няравын орлого зарлагын гүйлгээ журналын бичилттэй тохирсон боловч 2,3 дугаар сарын няравын тайлангийн орлого зарлагын гүйлгээ журналын бичилттэй зөрүүтэй, нягтлан бодогч хянасан гарын үсэг байхгүй.	1623.5	Зөвлөмж өгөх	Буянт-Ухаа дахь гаалийн газрын дарга, Санхүү аж ахуйн дарга, ерөнхий нягтлан бодогч	С. Цэцгээ Д. Эрдэнэсүх
2	2018 оны жилийн эцэст тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлийн дүн журналын үндсэн хөрөнгийн дүнтэй зөрүүтэй. Үндсэн хөрөнгө хүлээн авах, данснаас хасах анхан шатны маягт хөтлөөгүй.		Зөвлөмж өгөх	Буянт-Ухаа дахь гаалийн газрын дарга, Санхүү аж ахуйн дарга, ерөнхий нягтлан бодогч	С. Цэцгээ Д. Эрдэнэсүх
	Дүн	1623.5			

